

ОРХОН АЙМГИЙН ИТХ-ЫН СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ  
ДАГВАДОРЖ ОВОГТОЙ ДОРЖПҮРЭВИЙН СОНГУУЛИЙН  
МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Сонгуулийн уриа: Эрдэнэт-Бодлого-Хүн  
Зөв хүн-Зөв сонголт

Энэхүү мөрийн хөтөлбөр нь дараах 5 гол бодлого хэрэгжүүлэхэд чиглэгдэн боловсруулагдсан болно.


1. Ажилтай орлоготой - Эрдэнэт
2. Аюулгүй амар тайван - Эрдэнэт
3. Эрүүл чийрэг иргэдтэй - Эрдэнэт
4. Эрдэм боловсролтой - Эрдэнэт
5. Хариуцлагатай, хүнд сурталгүй – Эрдэнэт бодлого.

**Нэгдүгээр бодлогын хүрээнд:** Ажил хөдөлмөр эрхлэх чадвартай иргэдийг ажлын байраар хангах үүднээс жижиг дунд үйлдвэр, үйлчилгээг нэмэгдүүлэх ЖДҮ сан болон бусад дэмжлэгийн сангуудын үйл ажиллагааг ил тод хүртээмжтэй байхад анхааран дэмжиж ажиллах, бага орлоготой иргэдэд чиглэсэн тусгай хөтөлбөр боловсруулж өөрсдийнх нь оролцоог хангаж хэрэгжүүлэх, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-тай Эрдэнэт хотын ИТХ, ЗДТГ-ын зүгээс хамтран ажиллах гэрээг шинэчлэн боловсруулж гадаад улсаас импортоор авдаг бараа бүтээгдэхүүнийг Эрдэнэт хотдоо үйлдвэрлэж байгаа хувь хүн, аж ахуйн нэгжүүдийг бүрэн дүүрэн дэмжин, шинээр бий болоход анхаарч эрх зүйн орчинг бүрдүүлэхэд оролцон ажиллана. “Аялал жуулчлалын Эрдэнэт” бодлогыг боловсруулж хэрэгжүүлсэнээр ажлын байр нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана.

**Хоёрдугаар бодлогын хүрээнд:** Иргэдийн амьдарч байгаа орчин нөхцлийг сайжруулах, эко ногоон бүсийг олноор бий болгох, аюулгүй амьдрахад анхаарч иргэдийн оролцоог ханган хуулийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжин ажиллана. “Нэг айлаас Нэг хот” хөтөлбөр хэрэгжүүлэн иргэдийн оролцоонд тулгуурласан ажлуудыг холбогдох байгууллагуудтай хамтран явуулна.

**Гуравдугаар бодлогын хүрээнд:** Бүсийн оношлогоо эмчилгээний төв, Медипас болон иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж буй бусад эмнэлэгүүдийн ажиллах нөхцлийг сайжруулах, зайлшгүй техник, тоног төхөөрөмжөөр хангах, эмч эмнэлэгийн ажилтнуудыг давтан сургах, эрүүл мэндийн үйлчилгээг иргэд саадгүй түргэн шуурхай авч байх тал дээр анхаарах, мөн иргэдэд анхан шатны эмнэлэгийн тусламж үзүүлдэг Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг зориулалтын байр, техник, тоног төхөөрөмжтэй болгоход онцгой анхаарч үе шаттай шийдвэрлэнэ. Иргэдийг өвдсөний дараа бус өвдөхөөс өмнө эрүүл чийрэг байхад нийтийн биеийн тамир, спортын хөгжилд түлхэц болохуйц бодлого боловсруулан холбогдох байгууллагуудтай хамтран ажиллахад анхаарна.

**Дөрөвдүгээр бодлогын хүрээнд:** Улсын хөгжил бол хүний хөгжлийг нэн түрүүнд анхаарахаас эхэлнэ. Эрдэм мэдлэгтэй иргэн бол улс үндэстний үнэт баялаг. Хотын хүн ам өсөн нэмэгдэж буйтай холбогдуулан бага дунд насны хүүхдүүд рүү чиглэсэн бодлогын хүрээнд сургууль, цэцэрлэгийн хангалт хүртээмжийг нэмэгдүүлэх тал дээр үе шаттай бодлого боловсруулж хэрэгжүүлнэ. Залуу дунд үеийнхэнд чиглэсэн сургалт мэдлэг олгох хөтөлбөрүүдийг холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулж “Мэдлэгтэй-зөв-хариуцлагатай ЗАЛУУ” бодлогыг хэрэгжүүлж ажиллана. “Ахмадын үг”



нэртэй сургалт танин мэдэхүйн хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг ахмадуудтай хамтран боловсруулан хэрэгжүүлэхэд анхаарна.

**Тавдугаар бодлогын хүрээнд:** Албан тушаалтнуудын хариуцлагын тогтолцоог шинэчлэх шинэ хэв загварыг нэвтрүүлэхэд анхаарч ажиллана. Хариуцлагатай албан тушаалтан нь төрийн үйлчилгээг хүнд сурталгүй болгоход гол хөшүүрэг болно. Зөвхөн төрийн алба бус Эрдэнэт хотод үйлчилгээний үйл ажиллагаа явуулж буй бүх байгууллагын үйлчилгээний соёл хүнд сурталыг арилгахад холбогдох бодлого шийдвэр, хөтөлбөрүүдийг санаачилан хэрэгжүүлэн ажиллана.

Мөрийн хөтөлбөрийг боловсруулсан..........Д.ДОРЖПҮРЭВ

2020.07.22

